


Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал /2017 оны 3 дугаар сар/

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчимд агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $\text{PM}_{2.5}$ тоосонцор, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат болон автомат бус багажаар хэмжин тодорхойлж байна.

2017 оны 3 дугаар сард хэмжигдсэн агаар бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2016 оны 3 дугаар сартай харьцуулахад $\text{PM}_{2.5}$ тоосонцрын дундаж агууламж $4\text{мкг}/\text{м}^3$ -ээр буюу **8%**-аар, хүхэрлэг хийн дундаж агууламж $6\text{мкг}/\text{м}^3$ -ээр буюу **22%**-аар тус тус бага байсан бол PM_{10} тоосонцрын дундаж агууламж $9\text{мкг}/\text{м}^3$ -ээр буюу **10%**-аар, азотын давхар ислийн дундаж агууламж $4\text{мкг}/\text{м}^3$ -ээр буюу **9%**-аар их байсан байна. Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарыг агаар бохирдуулах бодис тус бүрээр дараах хэсэгт харуулав.

PM10 тоосонцор




Зураг 1. Хүйтний улирлын PM_{10} тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2017он

Агаарын чанарын суурин нийт харуулуудын дүнгээр PM_{10} тоосонцрын 2017 оны 3-р сарын дундаж агууламж $102\text{мкг}/\text{м}^3$ байгаа нь өмнөх оноос 10%-аар их байна (Зураг 1).

PM_{10} тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 3 дугаар сард 11 цэгт нийт 315 удаа хэмжилт хийснээс 161 удаа буюу 51% нь Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-аас давсан.

3 дугаар сард 24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баянхошуу орчимд $260\text{мкг}/\text{м}^3$ хүрсэн нь АЧС дахь ХА-тай харьцуулахад 2.6 дахин их байсан байна.

PM2.5 тоосонцор




Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2017он

Агаарын чанарын суурин харуулуудын дүнгээр PM2.5 тоосонцрын 2017 оны 3-р сарын дундаж агууламж 45мкг/м^3 -д хүрсэн бөгөөд өмнөх оноос 8%-аар бага байна (Зураг 2).

PM2.5 тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 3 дугаар сард нийт 7 цэгт 198 удаа тодорхойлсноос 95 удаа буюу 48% нь АЧС дахь ХА-аас давсан тохиолдол ажиглагдсан.

24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баянхошуу орчим 185мкг/м^3 хүрч АЧС дахь ХА-тай харьцуулахад 3.7 дахин их байсан байна.

Азотын давхар исэл (NO_2)




Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2012-2017он

Агаарын чанарын суурин нийт харуулуудын дүнгээр азотын давхар ислийн 2017 оны 3-р сарын сарын дундаж агууламж 42мкг/м^3 байгаа нь өмнөх оноос 9%-аар их байна (Зураг 3).

Азотын давхар ислийн 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 3 дугаар сард нийт 13 цэгт 385 удаа тодорхойлсноос 79 удаа буюу 21%-д нь АЧС дахь ХА-аас давсан.

24 цагийн дунджийн хамгийн их агууламж 13-р хороолол орчимд 119мкг/м^3 хүрсэн нь АЧС дахь ХА-тай харьцуулахад 2.4 дахин байсан байна.

Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2012-2017он

Агаарын чанарын суурин харуулуудын дүнгээр хүхэрлэг хийн 2017 оны 3-р сарын дундаж агууламж 20мкг/м³ хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 22%-аар бага байлаа (Зураг 4).

Хүхэрлэг хийн 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 3 дугаар сард нийт 14 цэгт 410 удаа хэмжилт хийснээс 48 удаа буюу 12%-д нь АЧС дахь ХА-аас давсан тохиолдол ажиглагдсан.


24 цагийн дунджийн хамгийн их агууламж Зурагт орчимд 100мкг/м³ хүрсэн нь АЧС дахь ХА-тай харьцуулахад 2 дахин их байсан байна.

2017 оны 3 дугаар сарын агаарын чанарыг индексээр үнэлэхэд


Улаанбаатар хотын агаарын чанарыг хянах автомат суурин харуулуудын 2017 оны 3 дугаар сарын дүнг индексээр тооцон тухайн орчны агаарын чанарыг үнэлэн дараахи хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1. Агаарын чанарын индексийн түвшин, өдрийн тоо

	Цэвэр	Хэвийн	Бага зэргийн бохирдолтой	Дунд зэргийн бохирдолтой	Их бохирдолтой	Маш их бохирдолтой
Нисэх	-	12	19	-	-	-
Толгойт	-	9	3	-	-	-
Баянхошуу	-	4	24	3	-	-
Зурагт	-	6	20	5	-	-
Амгалан	-	7	24	-	-	-
Баруун 4 зам	-	-	31	-	-	-
13-р хороолол	-	-	31	-	-	-
100 айл	-	6	22	-	-	-
Цахилгаан станц	1	8	22	-	-	-
Ургах наран хороолол	-	30	1	-	-	-



Зураг 5. Улаанбаатар хотын 2017 оны 3-р сарын агаарын чанарын индекс, %-аар



Зураг 6. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисуудын агаарын чанарын индекс, 2017 оны 3-р сар

Хүснэгт 1. 2017 оны 3-р сарын агаарын чанарын индекс

Он, сар, өдөр, гариг	Нисэх	Толгойт	Зурагт	Баянхошуу	100 айл	13-р хороолол	Баруун 4 зам	Амгалан	Цахилгаан станц	Ургах наран хороолол	
3/1/2017	Лхагва	138	180	238	152	147	234	198	184	177	122
3/2/2017	Пүрэв	164	152	292	322	166	238	198	136	148	80
3/3/2017	Баасан	108	88	204	196	148	214	174	84	76	69
3/4/2017	Бямба	62	87	88	66	70	172	152	94	64	78
3/5/2017	Ням	74	75	92	154	75	166	162	81	80	70
3/6/2017	Даваа	68	88	84	78	72	170	130	92	34	73
3/7/2017	Мягмар	98	69	204	128	137	214	196	112	86	66
3/8/2017	Лхагва	144	90	338	370	140	230	188	154	174	86
3/9/2017	Пүрэв	150	118	254	218	186	230	202	112	98	86
3/10/2017	Баасан	114	80	182	188	204	222	174	118	136	71
3/11/2017	Бямба	88	92	164	70		184	178	105	84	75
3/12/2017	Ням	146	96	210	178		232	174	153	145	78
3/13/2017	Даваа	148		268	158		232	192	112	163	71
3/14/2017	Мягмар	146		256	144	211	228	196	169	166	62
3/15/2017	Лхагва	118		214	171	171	212	194	92	138	78
3/16/2017	Пүрэв	89		174	137	173	210	180	149	118	71
3/17/2017	Баасан	72		172	101	175	186	186	139	111	73
3/18/2017	Бямба	104		176	82	72	188	154	87	124	69
3/19/2017	Ням	100		212	121	97	206	166	107	124	65
3/20/2017	Даваа	85		236	174	139	212	184	116	179	73
3/21/2017	Мягмар	77		86	154	210	196	172	153	105	66
3/22/2017	Лхагва	55		76	207	131	202	142	129	123	86
3/23/2017	Пүрэв	79		76	128	99	168	138	91	81	87
3/24/2017	Баасан	106		106	162	157	170	136	137	92	78
3/25/2017	Бямба	137		250	186	169	196	168	220	173	73
3/26/2017	Ням	141		194	130	147	214	182	130	168	70
3/27/2017	Даваа	132		186	211	155	216	188	128	159	78
3/28/2017	Мягмар	132		186	154	171	218	196	178	175	68
3/29/2017	Лхагва	114		108	168	186	172	142	195	117	87
3/30/2017	Пүрэв	159		182	153	157	218	198	208	181	72
3/31/2017	Баасан	168		164	260	177	220	198	240	194	73

Индексийн тоон үзүүлэлт	Агаарын чанар	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
0 - 50	Цэвэр	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
51-100	Хэвийн	Агаарын чанар шаардлага хангах боловч, зарим бохирдуулах бодисын нөлөөлөлд хэт мэдрэг хүмүүс өртөж болно. Тухайлбал, озон, нарийн ширхэглэгт тоосонцрын нөлөөллийн улмаас хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай.
101 – 250	Бага зэргийн бохирдолтой	Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө.
251 – 400	Дунд зэргийн бохирдолтой	Нийт хүн амын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөлөл илэрч эхэлнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ.
401 – 500	Их бохирдолтой	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц нөлөөлөл илэрнэ.
501<	Маш их бохирдолтой	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС